



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ  
ЭТГЭЭДҮҮДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.19 № 03/634  
танай 2024.04.17 -ны № 0 -г

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан НХААГ/20240103147 дугаартай “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан захиалагчаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>ТШЗ 19.2.3. Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт:</p> <p>1.Тендер илгээх маягыг V бүлгийн Маягт 1-ийн дагуу бөглөж, баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>2.Үйлчилгээ үзүүлэх ажлын хөтөлбөр болон арга аргачлалын талаарх танилцуулгыг V бүлгийн Маягт 5-ын дагуу бөглөж ирүүлнэ.</p> <p>3.Үйлчилгээ үзүүлэх хуваарийг V бүлгийн Маягт 6--ын дагуу ирүүлнэ.</p> <p>4.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг V бүлгийн Маягт 12-ын дагуу ирүүлнэ.</p> <p>5.Батлагдсан техникийн тодорхойлолтын хүрээнд санал зөвлөмж ирүүлнэ. зэрэг дээрх материалуудыг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлэх гэсэн байгааг дахин нягталж өгнө үү.</p>	<p>ТШЗ 19.2.3. Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт бичгийг гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй гэж залруулж байна.</p>
2	<p>ТШЗ 19.2. 3.5 Батлагдсан техникийн тодорхойлолтын хүрээнд санал зөвлөмжийн агуулгыг тодруулж өгнө үү.</p>	<p>“Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын техникийн тодорхойлолтыг судлан өөрийн хүрээнд санал зөвлөмж ирүүлэх шаардлагатай.</p>

Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 4.6 дахь хэсэгт “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.” гэсний дагуу тендер ирүүлнэ үү.